



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ТУШААЛЫН
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр

Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтэц, үндсэн үйлчилгээний чиг үүрэг, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.1, 2.1-д заасны үндэслэн Үндэсний аудитын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг нийтэд зарлаж байна.

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

Нэг. Дараах болзлыг хангасан албан хаагч, иргэн шалгалтад бүртгүүлнэ.

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин эмгэггүй байх;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх;

Хоёр. Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага

Ангилал зэрэглэл	Төрийн аудитын итгэмжит түшээ	
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эдийн засагч, нягтлан бодогч, инженер, эрх зүйч, социологч, бусад	
Мэргэшил	Эрхэлсэн түшмэлийн багц сургалтанд хамрагдсан байх;	
Туршлага	Төрийн албанд 16-аас доошгүй жил, үүнээс төрийн аудитын зөвлөх түшээ, түүнтэй адилтгах албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- Төрийн аудитын байгууллагын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; - Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн аудитын байгууллагаас улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, - үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргахад хяналт тавьж удирдлагаар хангах;



		- Төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх; - Төрийн аудитыг олон улсын болон үндэсний стандарт, дүрэм журам, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж хэрэгжилтийг хангуулах, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх; - Менежер, ахлах шинжээчийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажил үүргийг оновчтой хуваарилах, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; - Албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж удирдах, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшнийг нь үнэлэх; Эрсдэлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	- Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх; - Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, зөвлөгөө өгөх
	Асуудал шийдвэрлэх	- Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - Аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль, тогтоомжид тусгуулах тусгах санал боловсруулах; - Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - Гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - Бусад нийцсэн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх - Оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргахад удирдлагад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх
	Манлайлах	- Ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;



		- Нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчийн шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; - Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; - Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - Нэгжийн зорилтыг тодорхойлохдоо хамт олны саналыг сонсох, тусгах, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолох; - ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах - Хувийн зохион байгуулалтын хувьд үлгэр дуурайл үзүүлэх; - Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;
	Бусад	- Багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах; - Харилцааны орчин үеийн арга, хэлбэрийг ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх; - Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи, мэргэжлийн программ хангамжийг ашиглах хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - Англи, орос хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадварыг зохих түвшинд эзэмшсэн байх;

Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна.

Уг албан тушаалын сонгон шалгаруулалтад төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас эсхүл төрийн албаны удирдах албан тушаалын нөөцөд байгаа иргэд бүртгүүлэх боломжтой бөгөөд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.2-т заасан дарааллын дагуу нөхнө. Төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа албан хаагч бүртгүүлээгүй тохиолдолд төрийн албаны удирдах албан тушаалын нөөцөд байгаа иргэд сонгон шалгаруулалтад оролцоно.

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”-ын 2.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан төрийн албан хаагч бүртгүүлж болно.



- Төрийн албан хаагчийн анкет;
- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Иргэний үнэмлэхийн хуулбар, эх хувийн хамт;
- Боловсролын түвшнийг тодорхойлсон баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, эх хувийн хамт /албан тушаалын тодорхойлолтын туршлагын шаардлагад заасны дагуу төрийн аудитын итгэмжит түшээгийн болон эрхэлсэн түшмэлийн ангилалд ажилласныг нотлох тушаал, шийдвэрийг холбогдох байгууллагаас хуулбарлан авч ирэх бөгөөд байгууллагын “Хуулбар үнэн” дарж хавсаргах/;
- “4х6”-гийн хэмжээний цээж зураг
- 2017-2019 оны төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин үнэлсэн илтгэх хуудас /холбогдох байгууллагаас авч ирэх бөгөөд байгууллагын хуулбар үнэн дарж хавсаргах/;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол холбогдох баримт;

Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх

Сонгон шалгаруулалтын комисс тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг Засгийн газрын 4 дүгээр байрны 4 давхарт “Үндэсний аудитын газрын хурлын танхим”-д 2020 оны 2 дугаар сарын 13, 14-ны өдрүүдэд 09-12.30, 13.30-17.00 цагийн хооронд хүлээн авна.

Бүртгүүлэхээр ирсэн иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхийг комисс нягтлан шалгана.

Холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн албан хаагч, төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэнийг бүртгэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа хэлэлцэн гаргах ба болзол хангаагүй бол энэ тухай шалтгааныг мэдэгдэнэ.

Тав. Сонгон шалгаруулалтын хуваарь

Сонгон шалгаруулалтыг 2020 оны 2 дугаар сарын 19-өдрийн 10.00 дараах агуулгын хүрээнд зохион байгуулна. Үүнд:

1. Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;
2. Дүн шинжилгээ хийх чадвар;
3. Асуудал шийдвэрлэх чадвар;



4. Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар;
5. Удирдах зохион байгуулах чадвар;
6. Манлайлах чадвар;
7. Багаар ажиллах чадвар;
8. Оролцогчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин.

Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцох иргэд Иргэний үнэмлэхтэйгээ ирнэ.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Холбоо барих утас: 51-261585, 51-264229